



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/531

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийг батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны II/04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн баяр наадамд урилгаар оролцох гадаадын зочин төлөөлөгчдийг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.


2. Хавсралтад тусгагдсан 13,345,840 (арван гурван сая гурван зуун дөчин таван мянга найман зуун дөч) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

07 дугаар сарын 01-ны өдрийн А/СЗ.1 дугаар
Аймгийн Засаг даргын 2023 оны
захирамжийн хавсралт



АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ
ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Мөнгөн дүн /төгрөг/
1	Шатахуун	1,365,840
2	Байр, хоол	11,980,000
	Нийт дүн	13,345,840